

PLITONIT

МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН



PLITONIT Төгсгөл –Төгсгөл - ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 31358-2019 стандартад нийцсэн, өөрөө тэгшрэх, хурдан хатуурах, сайжруулсан тархах чадвартай төгсгөлийн шал тэгшлэгч



Төгсгөлийн цутгадаг хурдан хатуурдаг шал нь хуурай, нойтон, орон сууц, албан тасалгааны доторх бетонон шал, цул цементэн хавтанг тэгшлэх, засах зориулалттай. Энэ бүтээгдэхүүнийг нь хавтан, шалны хучилт, ламинат, кварц винил хавтан тавих, шалны халаалтын системд ашиглагддаг. Нийтийн эзэмшлийн талбай, орон сууц, тэр дундаа сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн байгууламж (эмчилгээ, урьдчилан сэргийлэх, амралт-сүвиллын байгууламжууд)-ын барилга, засварын ажилд хэрэглэж болно. Шалны бүрээсгүйгээр будах, ашиглах боломжгүй. Ашиглалтын явцад гадаргуугийн температур +5°C хэмээс +70°C хэм хүртэл байна.

Давхаргыг тэгшлэх үеийн зузаан нь 2-оос 20 мм-ийн хооронд байна

Савлагаа — 20 кг

- ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 31358 стандартаар шахалтын бат бэхийн ангилал B12,5
- ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 31358 стандартаар сайжруулсан тархах чадвар 300мм-ээс багагүй – хөдөлгөөнтэй марк Rk7
- Маш гөлгөр гадаргуу
- Давхаргын хамрах хүрээ өргөн
- Хурдан хатуурах хугацаатай 6 цагийн дараа дээгүүр нь алхаж болно

Бүтээгдэхүүний зарцуулалт

1 мм зузаантай түрхэх үед 1,6 кг/м².

Ажлын нөхцөл

Зуурмагийн хольцыг зөвхөн барилга дотор хэрэглэнэ. Ажлын явц болон гүйцэтгэлээс хойших 3 хоногт агаарын температур +10°C хэмээс +30°C хэмийн хооронд байх нь зохимжтой. Ажлын явцад зуурмагийн болон суурийн температур +10°C хэмээс +30°C хэмийн хооронд байх нь зохимжтой. Ажлын явцад агаарын харьцангуй чийгшил 60% -иас багагүй байна. Дараагийн 3 хоногт гадаргууг нарны шууд тусгал, нэвт салхинаас хамгаалах хэрэгтэй.

Цутгах шалны доорх суурийг бэлтгэх

Хэрэв цутгах суурь нь 20 мм-ээс дээш өндрийн зөрөөтэй бол зузаан давхаргатай тэгшлэгч (жишээлбэл, PLITONIT P1 Pro) ашиглан гадаргууг урьдчилан тэгшлэх шаардлагатай. Суурь нь бат бөх байх ёстой (бетоны B15 ба түүнээс дээш маркийн, 20 МПа-аас багагүй шахалтын бат бэх цементэн хучилттай), бүтцийн хувьд даацын, хагаралгүй байх ёстой. Суурийн гадаргууг тоос, шороо, шохой, тос, өөх тос, битум, органик болон эрдэс наалдамхай цавуу, будгийн үлдэгдэл, түүнчлэн усанд уусдаг бодисоос сайтар цэвэрлэнэ. Суурийг тоосноос бүрэн цэвэрлэхийн тулд тоос сорогч ашиглана уу.

Шалны тэгшлэх давхаргыг хана, шалны хашилтаас 1,5-2 см-ийн зайд нимгэн полистирол хөөс эсвэл полиэтилен хальсаар бүрхсэн модон рейкээр урьдчилан тусгаарлах шаардлагатай. Шаардлагатай тэгшлэх түвшинг тодорхойлохын тулд PLITONIT өөрөө наалддаг лавлах босоо дохиог суурилуулах шаардлагатай. Хамгийн сайн үр дүнд хүрэхийн тулд тэгшлэх гадаргууг TM PLITONIT хөрсжүүлэгчээр боловсруулах шаардлагатай. Хөрсжүүлэгчийг сойз, багс эсвэл булаар түрхэнэ. Хөрсжүүлэгч нь нимгэн тасралтгүй давхарга үүсгэх ёстой, илүүдсэн усан шалбааг үүсгэхийг зөвшөөрдөггүй. Хөрсжүүлсэн гадаргуугийн чанарыг 20-30 минутын дотор ус шингээхгүй байх замаар тодорхойлно. Гөлгөр, нягт гадаргууг (цул бетон, шалны хавтан гэх мэт) PLITONIT СуперКонтакт болон PLITONIT БетонКонтакт хөрсжүүлэгчээр боловсруулна.

Зуурмагийн хольц бэлтгэх

Зуурмагийг бэлтгэхийн тулд энгийн үндны усыг ашиглана. Холих харьцаа : 1 уут хуурай цавууны хольцод 5,0 - 5,2 литр ус шаардагдана. Хуурай хольцыг тасалгааны температурт урьдчилан хэмжсэн зохих хэмжээний ус уруу хийгээд цахилгаан холигч эсвэл цахилгаан өрөм ашиглан нэгэн төрлийн жигд болтол нь холино. Эргэлтийн хурд нь 600 эрг / мин-ээс ихгүй байна. Бэлэн болсон уусмалын хольцыг 20±2°C-ийн температурт 30 минутын дотор ашиглана.

Ажлын дараалал

Ажил эхлэхийн өмнө хоёр сав, зарцуулагдах хэмжээний хуурай хольц, онгойлгосон, тавьсан уутнууд, ус, ус хэмжих аяга бэлэн байх ёстой. Хаалганаас хамгийн хол байгаа хананаас ажлаа эхлэхийг зөвлөж байна. Түвшин тэгшлэх нийлмэл массыг ойролцоогоор 50 см өргөнтэй ханатай зэрэгцээ зурвасаар цутгаж, хоёр хэсгийн хоорондох холболтын хугацаа 30 минутаас хэтрэхгүй байх ёстой. Гадаргуу дээр тэгшлэх найрлагыг илүү сайн тараахын тулд өргөн хусуур эсвэл зүүтэй булыг ашиглах шаардлагатай. Ажлыг хамгийн дээд хурдыг хадгалж, тасалдалгүйгээр хийх ёстой. Сууринд тэгшлэгчээс давхарга үүсээгүй бага зэргийн хагарал үүссэн үед шалны чанарт нөлөөлөхгүй.

Анхааруулга

Ажлыг хоёр хүний бүрэлдэхүүнтэй баг хийхийг зөвлөж байна. Ус хэтрүүлэн хэрэглэхийг зөвшөөрөхгүй. Цутгалтыг хийснээс хойш 3-4 цагийн өмнө тэгшилсэн гадаргуу дээр алхахыг зөвшөөрнө. Керамик хавтанг 8 цагийн дараа тавьж болно. Керамик хавтанг тавихаас өмнө тэгшилсэн гадаргууг PLITONIT Хөрсжүүлэгч 1 Profi хөрсжүүлэгчээр боловсруулна. Бусад PLITONIT шингээгч хөрсжүүлэгчийг ашиглах боломжтой. Ойролцоогоор 24 цагийн дараа ламинат, паркетан хавтанг тавих боломжтой бөгөөд энэ нь суурийн чийгийн агууламж нь шалны бүрээс үйлдвэрлэгчийн заавраар зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрэхгүй байх ёстой. Суурийн чийгийн түвшинг үнэлэхийн тулд шалны бүрээс үйлдвэрлэгчийн зааварт заасан аргуудыг ашиглахыг зөвлөж байна. Дээр заагдсан шинж чанарууд нь орчны температур (20±2)°C, агаарын харьцангуй чийгшил (60±10)%-д үйлчилнэ. Ажлыг гүйцэтгэхдээ барилгын ерөнхий ажил гүйцэтгэх зааварчилга, барилга угсралтын ажилд мөрдөгдөх аюулгүй ажиллагааны зааварчилгыг дагаж мөрдөх ёстой. Шалны халаалтын системийг 7 хоногийн дараа залгаж болно.

Аюулгүй ажиллагаа

Хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 12.1.007 стандартын дагуу аюулын 4-р (бага аюултай бодис) ангилалд хамаарна. Ажил гүйцэтгэхдээ бээлий, нүдний шил, амны хаалт хэрэглээрэй. Зуурмагийг арьс, нүдэнд хүрэхээс зайлсхийх. Нүдэнд хүргэсэн тохиолдолд нэн даруй их хэмжээний усаар зайлна. ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГААРАЙ.

Тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл

Хуурай хольцыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Хуурай хольцтой уутыг савлагааны аюулгүй байдал, чийгээс хамгаалсан хуурай өрөөнд хадгална. Бүтээгдэхүүний хадгалах хугацаа нь үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар байна.

Орц, найрлага

Гөлтгөнө холбогч, эрдэс бодисын дүүргэгч, портландцемент, сайжруулагч нэмэлт.

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч энэ зааврын тээвэрлэлт, хадгалалтын нөхцөл, зааврыг дагаж мөрдсөн тохиолдолд хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн ГОСТ Р 31358 стандарт, С2 Е S2 ангилал болон 23.64.10-277-515521552017 техникийн нөхцөлийн шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулж байна. Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй. ГОСТ Р 8.579-2001 стандартын дагуу цэвэр жингийн хазайлт байна. Бүтээгдэхүүнийг бүх төрлийн иргэний барилгад ашиглахыг зөвшөөрсөн (Аэфф <370 Бк/кг байх ОХУ-ын "Цацрагийн аюулгүй байдлын стандартууд" НРБ-99/2009, ариун цэврийн дүрэм, журам СанПиН 2.6.1.25.23-09 нийцсэн.

Техник үзүүлэлтүүд

Хуурай хольцын хувьд	
1 мм-ийн зузаантай давхаргаар түрхэх үед зарцуулалт	1,6 кг/м ²
Хамгийн том дүүргэгч ширхгийн хэмжээ	1,25 мм
Том хэмжээтэй ширхгийн агууламж	0%
Холих усны зарцуулалт: • 20 кг уут	5,0-5,2 л
Хэрэглэхэд бэлэн хольцын хувьд	
Хөдөлгөөнтэй чанар (цагираг тархалт)	300 мм-ээс багагүй
Ашиглахад бэлэн хольцыг хэрэглэх хугацаа	30 минутаас ихгүй
Хатуурсан зүүрмагийн хувьд	
7 хоногийн дараа хэвийн нөхцөлд шахалтын бат бэх чанар	16 МПа багагүй
7 хоногийн дараа суурьтай наалдсан бат бэх чанар	0,6 МПа багагүй
Суултын деформац	0,5 мм/м ихгүй
Өргөтгөлийн деформац	0,5 мм/м ихгүй
Ашиглалтын үеийн температурын горим	+70°C хүртэл
Байгалийн радионуклидын цацраг идэвх	370 Бк/кг ихгүй

Логистикийн мэдээлэл

Хувийн бар-код 4607013045774

Нэг багц дахь уутны тоо – 48 ширхэг